



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/144

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21^б.2, 21^б.3, 21^б.4, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийг дэмжих сангаас эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээнд зарцуулах 42.500.000 /дөчин хоёр сая таван зуун мянган/ төгрөгийн санхүүжилтийн эрхийг Нийслэлийн эрүүл мэндийн газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвд хавсралтын дагуу шилжүүлсүгэй.
2. Хуваарилсан санхүүжилтийг хууль, журмын дагуу холбогдох байгууллагуудад шилжүүлж, санхүүжүүлэн ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Ганцэцэг/-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Баярт/-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080670

Эрүүл мэндийн сайдын 2018
оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн
А/1144 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГААС САНХҮҮЖИЛТ-ОЛГОХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС, САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ

№	Нэрс	Санхүүжилтийн хэмжээ /төг/
1	Нийслэлийн эрүүл мэндийн газар	8.500.000
2	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	8.500.000
3	Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг	8.500.000
4	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	8.500.000
5	Хавдар судлалын үндэсний төв	8.500.000
	Нийт	42.500.000